



УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.7, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Стратеги төлөвлөгөө 2020-2024 он, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Ажилтан хөгжүүлэх хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
2. Ажилтан хөгжүүлэх хөтөлбөрийг зохих журмын дагуу хэрэгжүүлэн ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн алба /П.Анхтуяа/, Сувилахуйн алба /Ц.Амаржаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Ажилтан хөгжүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, дэмжлэгт удирдлагаар ханган ажиллахыг Сургалт, эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал /Ч.Энхболд/-д даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбоотой Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2014 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн "Хөтөлбөр батлах тухай" А/191 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



000039

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий
захирлын 2022 оны ... дүгээр сарын ... -ны
өдрийн ... дугаар ... ушааны хавсралт



АЖИЛТАН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР 2022 ОН

БОЛОВСРУУЛСАН: Ч.Бямбасүрэн – Захиргаа, хүний нөөцийн албаны менежер

ХЯНАСАН: П.Анхтуяа – Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх алба: Захиргаа, хүний нөөцийн алба

Хөтөлбөр хэрэгжих он сар өдөр: 2022 оны 01 дүгээр сарын 03

Улаанбаатар хот 2022 он

АЖИЛТАН ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1.1 Монгол улсын “Эрүүл мэндийн тухай хууль”, “Хөдөлмөрийн тухай хууль”, “Төрийн албаны тухай хууль”, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Стратеги төлөвлөгөө 2020-2024 он, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, Хүний нөөцийн төлөвлөлт 2013-2023 он, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд багтана.

1.2 УНТЭ-ийн “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр” нь ажилтанд багц мэдлэг олгох, сургаж- дадлагажуулах, хөгжүүлэх, мэдлэг, ур чадвар – хандлагыг цогцоор нь төлөвшүүлэх хүний нөөцийн хөгжлийн гол баримт бичиг юм.

Хоёр. Зорилго

2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дэлхийн жишигт хүргэх чадварлаг хүний нөөцийг хөгжүүлэн бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжоор хангах, өрсөлдөх чадвар бүхий өндөр мэргэшсэн багийг бүрдүүлэхэд оршино.

Гурав. Хамрах хүрээ

3.1 Улсын нэгдүгээр төв эмнэлэгт ажиллаж буй нийт ажилтан хамрагдана. Үүнд:

3.1.1 Шинэ ажилтан

3.1.1.1 УНТЭ-т дадлага хийж буй анагаахын их, дээд сургуулийн оюутан

3.1.1.2 УНТЭ-т төгсөлтийн дараах сургалтаар бусад эрүүл мэндийн

байгууллагуудаас ирж суралцаж буй суралцагч эмч нар

3.1.1.3 УНТЭ-т дагалднаар суралцах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

3.1.1.4 УНТЭ-т дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

3.1.1.5 УНТЭ-т туршилтын хугацаагаар ажиллах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

3.1.1.6 УНТЭ-т улирлын шинжтэй ажил гүйцэтгүүлэх байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

3.1.1.7 УНТЭ-т ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

3.1.1.8 УНТЭ-т түр ажлын байранд ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан

- 3.1.1.9 УНТЭ-т өмнө ажиллаж байсан боловч урт хугацаанд завсардсан ажилчид /Урт хугацааны захиргааны чөлөөтэй байсан болон чөлөөлөгдөөд эргэн томилогдсон ажилчид/
- 3.1.1.10 УНТЭ-ийн нийт шинэ ажилтан
 - 3.1.1.10.1 Шинээр ажилд орж буй ажилтан
 - 3.1.1.10.22 хүртэл жил ажиллаж буй ажилтан
- 3.2 Дадлагажиж буй ажилтан
 - 3.2.1 УНТЭ-т 3-4 дэх жилдээ ажиллаж буй ажилтан
- 3.3 Дадлагажсан ажилтан
 - 3.3.1 УНТЭ-т 5-10 дахь жилдээ ажиллаж буй ажилтан
 - 3.3.2 УНТЭ-т 11-15 дахь жилдээ ажиллаж буй ажилтан
 - 3.3.3 УНТЭ-т 16-21 дахь жилдээ ажиллаж буй ажилтан
 - 3.3.4 УНТЭ-д 22-25 дахь жилдээ ажиллаж буй ажилтан
 - 3.3.5 УНТЭ-д 25-аас дээш жилдээ ажиллаж буй ажилтанд хүнээ хөгжүүлэх тусгай хөтөлбөр хэрэгжнэ.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжих хугацаа

4.1 Байгууллагын стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжих хугацаанд буюу 2024 оныг дуустал хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжинэ.

Тав. Шинэ ажилтанд чиглэсэн үйл ажиллагаа

- 5.1 Шинэ ажилтанг ажилд авахтай холбоотой эрх зүйн болон бусад зохицуулалтууд
 - 5.1.1 Хөдөлмөрийн гэрээ байгуулах
 - 5.1.2 Албан тушаалын тодорхойлолт танилцуулах
 - 5.1.3 Тушаал гаргах
 - 5.1.4 Хувийн хэргийн бүрдүүлэлт болон бусад
 - 5.1.5 Эрүүл мэндийн үзлэг болон вакцинжуулалтад хамруулах
- 5.2 Шинэ ажилтанг Захирлын зөвлөлд танилцуулах, хэтийн зорилго, төлөвлөгөөг сонсон танилцах үйл ажиллагааг зохион байгуулах
- 5.3 Багц мэдлэг олгох сургалтанд хамруулах
- 5.4 Байгууллагын үнэт зүйлийг эрхэмлэх, соёлыг төлөвшүүлэх чиглэлээр хүндэтгэлийн уулзалт зохион байгуулах
- 5.5 Хувь хүнийг нээн илрүүлэх ба хувь хүний хөгжлийн анхан шатны сургалтад хамруулах
- 5.6 Шинэ ажилтны дасан зохицох үйл ажиллагааг тусгай хөтөлбөрөөр зохицуулна.

Зургаа. Дадлагажиж буй ажилтанд зориулсан хөтөлбөр

- 6.1 Дадлагажиж буй ажилтанг тухайн хугацаанд ажилд нь бүрэн гаршуулах
- 6.2 Мэргэжлийн сургалтуудад хамруулах, туршлагажуулах
 - 6.2.1 Мэргэшил олгох болон дээшлүүлэх сургалтуудад хамруулах
 - 6.2.2 Нэгжийн хооронд сэлгэн болон шилжүүлэн ажиллуулж сургах
- 6.3 Хувь хүний хөгжлийн ахисан шатны сургалтуудад хамруулах
 - 6.3.1 Ажилтны өөрийгөө маркетинг чадварууд болон ажилтны нөөц бололцоог нээх чадварыг эзэмшүүлэх
 - 6.3.2 Ажилтны суралцах болон багаар ажиллах ур чадварыг эзэмшүүлэх
 - 6.3.3 Ажилтны өөртөө итгэлтэй харилцааны ур чадварыг эзэмшүүлэх
 - 6.3.4 Ажилтны амжилтын сэтгэлзүйг бэлтгэх сургалтанд хамруулах

Долоо. Дадлагажсан ажилтанд зориулсан хөтөлбөр

- 7.1 УНТЭ-т 5-10 дахь жилдээ ажиллаж буй ажилтанг хөгжүүлэх хөтөлбөр
 - 7.1.1 Мэргэшлийн ахлах зэрэг хамгаалахыг дэмжих
 - 7.1.2 Мэргэшил дээшлүүлэх сургалтуудад хамруулах
 - 7.1.3 Магистрын болон докторын сургалтанд суралцах боломж нөхцлөөр хангах, дэмжих
 - 7.1.4 Шинэ инноваци, технологид суурилан гадаадад суралцуулах
 - 7.1.5 ОУ-ын хурал, семинар, сургалтанд хамруулах
 - 7.1.6 Ажилтнуудын хэлний мэдлэгийн түвшинг ахиулах
- 7.2 УНТЭ-т 11-21 дэх жилдээ ажиллаж буй ажилтанг хөгжүүлэх хөтөлбөр
 - 7.2.1 Мэргэшлийн тэргүүлэх зэрэг хамгаалахыг дэмжих
 - 7.2.2 Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах
 - 7.2.3 Магистрын болон докторын сургалтанд суралцах боломж нөхцлөөр хангах, дэмжих
 - 7.2.4 Сурган заах арга зүйн сургалтанд хамруулах
 - 7.2.5 Төгсөлтийн дараах сургалтанд хичээл заалгах
 - 7.2.6 ОУ-ын хурал, семинар, сургалтанд хамруулах
 - 7.2.7 Шинэ инноваци, технологид суурилан гадаадад суралцуулах
 - 7.2.8 Ажилтнуудын хэлний мэдлэгийн түвшинг ахиулах
 - 7.2.9 Олон улсын ажлын байрны жишигт нийцсэн ажилтанг бэлтгэх
- 7.3 УНТЭ-д 22-25-аас дээш жилдээ ажиллаж буй ажилтанг хөгжүүлэх хөтөлбөр
 - 7.3.1 Мэргэшлийн зөвлөх зэрэг хамгаалахыг дэмжих

- 7.3.2 Докторын сургалтанд суралцах боломж нөхцлөөр хангах, дэмжих
- 7.3.3 Сурган заах арга зүйн сургалтанд хамруулах
- 7.3.4 Төгсөлтийн дараах сургалтанд хичээл заалгах
- 7.3.5 ОУ-ын хурал, семинар, сургалтанд хамруулах, дэмжих
- 7.3.6 Шинэ инноваци, технологид суурилан гадаадад суралцуулах
- 7.3.7 Дэд профессор, профессор цол хамгаалахад дэмжих

Найм. Ажилтнуудыг сурган залгамж халааг тасралтгүй бэлтгэх үйл ажиллагаа

8.1 УНТЭ-д 25-аас дээш жил ажилласан болон өндөр чадамжтай эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан нь шинэ, дадлагажиж буй болон дадлагажсан ажилтнуудыг сурган залгамж халааг тасралтгүйгээр бэлтгэнэ. Үүнд:

- 8.1.1 Шинэ, дадлагажиж буй болон дадлагажсан ажилтнуудыг ёс зүй болон хандлагаараа үлгэрлэн манлайлах
- 8.1.2 Шинэ, дадлагажиж буй болон дадлагажсан ажилтнуудад мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх
- 8.1.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлсэн болон хэрэгжүүлэн ажиллаж буй шинэ технологи, инновацийн хүрээнд залгамж халаагаа бэлтгэх, зөвлөн чиглүүлэх

Ес. “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд ажилтанд үзүүлэх дэмжлэг

Д/д	Ажилтан	Ангилал	Хугацаа	Дэмжлэг
1	Шинэ ажилтан	УНТЭ-т дадлага хийж буй анагаахын их, дээд сургуулийн оюутан	2 хүртэлх жилдээ ажиллаж буй	Хөнгөлөлт, дэмжлэг олгогдохгүй
		УНТЭ-т төгсөлтийн дараах сургалтаар бусад эрүүл мэндийн байгууллагуудаас ирж суралцаж буй суралцагч эмч нар		Хөнгөлөлт, дэмжлэг олгогдохгүй
		УНТЭ-т дагалднаар суралцах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан		Хөнгөлөлт, дэмжлэг олгогдохгүй
		УНТЭ-т дагалднаар ажиллах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан		Хөнгөлөлт, дэмжлэг олгогдохгүй
		УНТЭ-т туршилтын хугацаагаар ажиллах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан		

		УНТЭ-т улирлын шинжтэй ажил гүйцэтгүүлэх байгуулсан хөдөлмөрийн гэрээтэй ажилтан УНТЭ-т ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан УНТЭ-т түр ажлын байранд ажиллуулах хөдөлмөрийн гэрээтэй ажилтан УНТЭ-т өмнө ажиллаж байсан боловч урт хугацаанд завсардсан ажилчид /Урт хугацааны захиргааны чөлөөтэй байсан болон чөлөөлөгдөөд эргэн томилогдсон ажилчид/ 2 хүртэл жил ажиллаж буй ажилтан		Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ"-нд тусгагдсан хөнгөлөлт, тэтгэмж, туслалцааг үзүүлэх
2	Дадлагажиж буй ажилтан	3-4 жилдээ ажиллаж буй ажилтан	3-4 жилдээ ажиллаж буй	Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ"-нд тусгагдсан хөнгөлөлт, тэтгэмж, туслалцааг үзүүлэх Ажилтны ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж ур чадварын нэмэгдлийг олгох эсэх асуудлыг шийдвэрлэх Байгууллагын шагнал болон нийгэмлэг, холбоодын шагналд тодорхойлох
3	Дадлагажсан ажилтан	УНТЭ-т 5-10 дахь жилдээ ажиллаж буй ажилтанг		Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ"-нд тусгагдсан хөнгөлөлт, тэтгэмж, туслалцааг үзүүлэх Ажилтны ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж ур чадварын нэмэгдлийг олгох эсэх асуудлыг шийдвэрлэх ОУ-ын хурал, семинар, сургалтанд хамруулах Эрүүл мэндийн яамны жуух бичигт журмын дагуу тодорхойлох Байгууллагын "Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ"-нд тусгагдсан хөнгөлөлт, тэтгэмж, туслалцааг үзүүлэх

		УНТЭ-т 11-21 дэх жилдээ ажиллаж буй ажилтан	5-25 болон түүнээс дээш жил ажиллаж буй	Ажилтны ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг нь дэмжиж ур чадварын нэмэгдлийг олгох эсэх асуудлыг шийдвэрлэх
		УНТЭ-д 22-25 жилдээ ажиллаж буй ажилтан		Мэргэжлийн зэрэг хамгаалах, мэргэжил дээшлүүлэхэд ажлын ачаалалд зохицуулалт хийх, цалинтай чөлөө олгох
				Магистр болон докторын зэрэг хамгаалахад цалинтай чөлөө олгох
				Чадавхижуулах бусад сургалтанд хамруулах
				ОУ-ын хурал, семинар, сургалтанд хамруулах, шинэ инноваци, технологид суурилан гадаадын томосхон эмнэлгүүдэд туршлага судлуулах
				Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан болон МУ-ын төрийн одон, медаль, цолд журмын дагуу тодорхойлох
		25-аас дээш жил ажиллаж буй ажилтан		11-21, 22-25 жилдээ ажиллаж буй ажилтанд олгогдох хөнгөлөлт, дэмжлэг, тусалцаа бүгд үзүүлэгдэнэ

Арав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэн зохион байгуулах

10.1 Захиргаа, хүний нөөцийн алба “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллана.

10.2 Ажилтан хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Сувилахуйн алба шинэ, дадлагажиж буй, дадлагажсан сувилагч хөтөлбөрийг боловсруулан ажиллана.

10.3 Салбартаа мэргэшсэн байдал, багш нарын нэр хүнд, туршлага, сургалтын арга барил, хэлбэр зэргийг харгалзан сургалтын байгууллагыг сонгон ажилтныг хөгжүүлэх сургалтыг хамтран зохион байгуулж ажиллана.

10.4 “Ажилтан хөгжүүлэх хөтөлбөр”-ийг шаардлагатай тохиолол бүрт шинэчлэн нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБА